



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01/08

Арвайхээр

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.9, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн саналыг харгалзан аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий худалдааны газруудад тогтоосон цагийн хуваарийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын 14, 21, 28-ны өдрүүдийн “Баасан” гарагт архи, согтууруулах ундаа худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Тусгай зөвшөөрөл бүхий худалдааны газруудад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0022